



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР

МЭДЭГДЭЛ

2024.01.17

Eguur.mn сайтад 2024 оны 01 сарын 10-ны өдөр нийтлэгдсэн “М.Бадарчийн найдаж буй спортын арбитр гэх ТББ нэг бөхөөс ₮5 сая төрөг авч, барилдах эрхийг сэргээж байна” гэсэн агуулга бүхий илт худал мэдээллийн талаар Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитраас дараах мэдэгдлийг хүргүүлж байна.

Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитр Монгол улсдаа төдийгүй Олон Улсын Спортын арбитр, Дэлхийн допингийн эсрэг байгууллага, Олон улсын Олимпын хороо зэрэг олон улсын байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн спортын маргааныг шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага билээ.

Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцын дагуу Спортын арбитр болон Допингийн давж заалдах комисс гэсэн байгууллагад Спортын болон Допингийн маргааныг шийдвэрлэх, хяналт тавихыг үүрэг болгосны дагуу ажиллаж байна.

Спортын арбитр нь өөрийн хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, Допингийн давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм зэргийг Дэлхийн допингийн эсрэг байгууллагаар хянуулж, батлан үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг төдийгүй Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 376 дугаар тогтоолоор батлагдсан Допингийн эсрэг үндэсний дүрэм болон Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Шинжилгээ мөрдөн шалгалтын Олон улсын стандарт зэрэг баримт бичгүүдийг үндэслэн үйл ажиллагаа явуулдаг тул хяналт, зохицуулалтгүй байгууллага биш юм.

Мөн Спортын арбитрын дэргэд Үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Допингийн давж заалдах комисс байгуулагдаж, уг комисс нь Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Допингтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэдэг.

Манай байгууллага 2017 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш шийдвэрлэсэн хэрэг маргааны хувьд хууль бусаар ажилласан зүйл байхгүй, холбогдох дүрэм, журам, Олон улсын гэрээ, конвенц, стандартын дагуу хэргийг шийдвэрлэж байгаа бөгөөд манай байгууллагын шийдвэр Монгол Улсын шүүх болон Олон Улсын спортын шүүхэд тус тус хянагддаг.

Eguur.mn сайт илт худал, бодит байдлыг гуйвуулсан мэдээллийг олон нийтэд тарааж байгууллагын нэр хүндэд халдаж байна.

Цаашид байгууллагын нэр хүндэд халдсан худал мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээхгүй байхыг Eguur.mn сайтаас шаардаж, эрх бүхий байгууллагад хандах болно гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР
ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС